# 19.14. Төсөл, хөтөлбөрийн мэдээлэл импортлох

Төсөл, хөтөлбөрийн мэдээллийг эксел файл дээр бэлдэж татах боломжтой. Импортлох эксел файлын загвар нь системийн **Дата импорт ->Төсөл, хөтөлбөр-> Загвар татах -> ProjectImportTemplate.xlsx** гэсэн нэртэй файл байна.




### Өмнөх нөхцөл

- Сургалтын байгууллага идэвхтэй төлөвтэй байна.
- Салбар, бүрэлдэхүүн сургууль үүсгэсэн байх, төлөв нь идэвхтэй байх.
- Сургалтын нэгж үүсгэсэн байх, төлөв нь идэвхтэй байх.

### Зөвлөмж

- Тоо төрлийн талбарт зөвхөн тоон утга оруулна.
- Огноо төрлийн талбарт он-сар-өдөр форматаар оруулна.
- Текст төрлийн талбарт тоо, үсэг, тэмдэгтээс бүрдсэн мэдээлэл оруулна.
- Ганц сонголт талбарт өгөгдсөн ангилалаас нэгийг сонгоно.
- Заавал бөглөх талбарын өгөгдлийг оруулсан байх.
- Тухайн мэдээлэл дэх код, нэрийг давхцуулахгүйгээр оруулах

### Файлын баганын мэдээлэл

| **Баганы нэр** | **Төрөл** | **Тайлбар** | **Заавал бөглөх талбар эсэх** |
|---|---|---|---|
| Сургалтын байгууллагын код | Текст | Төсөл, хөтөлбөрийн харъяалагдах сургалтын байгууллагын кодыг | Заавал |

| | | | |
|---|---|---|---|
| | | оруулна. Энэ нь Дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд сургалтын байгууллагыг давхцахгүй байдлаар кодолсон код юм. Систем тухайн кодоор сургалтын байгууллагыг танина. Код буруу оруулсан тохиолдолд алдаа заана. Сургалтын байгууллагын кодыг **Систем > Манай байгууллага > Ерөнхий мэдээлэл таб > Үндсэн мэдээлэл хэсэг > Код** талбараас  харна уу! | |
| Төрөл | Сонголт | Дээд боловсролын сургалтын байгууллагад тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн төрлийг сонгоно. | Заавал |
| Төсөл хөтөлбөрийн код | Текст | Дээд боловсролын сургалтын байгууллагад тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн кодыг давхцахгүй байдлаар үүсгэн оруулна. | Заавал |
| Төсөл хөтөлбөрийн нэр | Текст | Дээд боловсролын сургалтын байгууллагад тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн нэрийг давхцахгүй байдлаар үүсгэн оруулна. | Заавал |
| Тайлбар | Текст | Дэлгэрэнгүй мэдээллийг оруулна. | Нэмэлт |
| Эхлэх огноо | Огноо | Дээд боловсролын сургалтын байгууллагад тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн эхэлсэн огноо бичнэ. | Заавал |
| Дуусах огноо | Огноо | Дээд боловсролын сургалтын байгууллагад тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн дуусах огноо бичнэ. | Заавал |
| Гүйцэтгэлийн хувь | Тоо | Дээд боловсролын сургалтын байгууллагад тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн нийт | Нэмэлт |

| | | | |
|---|---|---|---|
| | | гүйцэтгэлийн хувь бичнэ. /Төсөл, хөтөлбөрийн ажлын төлөвлөгөөний явц, гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийж нийт гүйцэтгэлийн хувь бодож гаргана./ | |
| Валют | Сонголт | Төсөл, хөтөлбөрийн төсөв, санхүүжилтийг тооцох валютын нэгжийг сонгоно. | Заавал |
| Нийт төсөв | Тоо | Төсөл, хөтөлбөрийн нийт төсөв, өртгийг бичнэ. | Заавал |
| Нийт зарцуулалт | Тоо | Төсөл, хөтөлбөрийн нийт зарцуулалтыг бичнэ. | Заавал |
| Хамтарсан төсөл эсэх | Сонголт | Тухайн хэрэгжүүлж буй төсөл нь өөр байгууллагатай хамтарсан эсэхийг сонгоно. | Нэмэлт |